БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрүүл мэндийн салбарын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/22/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

**Агуулга**


1 Аудитын гэрчилгээ ..... 3
2 Аудитын тайлан ..... 5
2.1. Оршил ..... 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт..... 6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... 7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 8
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 8
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 9
2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар..... 9
2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар..... 10
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 10
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... 10
2.11. Шилэн дансны мэдээлэл..... 11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 11
2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:..... 11
2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 12
3 Аудит хийсэн санхүүгийн тайлан..... 13

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2019.03.25 № 2/164

танай ______________-ны №______________-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
В.НАРАНТУЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрүүл мэндийн салбарын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Эрүүл мэндийн салбарын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн салбарын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

E:\ajil\2019 on\STA 2018\21. Eruul mendiin negtgel\4.Tailagnal\Эрүүл мэндийн салбарын нэгтгэл гэрчилгээ.docx

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Эрүүл мэндийн салбар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

E:\ajil\2019 on\STA 2018\21. Eruul mendiin negtgel\4.Tailagnal\Эрүүл мэндийн салбарын нэгтгэл гэрчилгээ.docx

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Эрүүл мэндийн салбарын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга В.Нарантуяад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,3-д заасны дагуу Эрүүл мэндийн салбарын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн салбарын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 15-наас 2019 оны 03 дугаар сарын 20–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Азбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн салбарын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн № 122 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрүүл мэндийн салбарын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар нь “Нийгмийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгон ёс зүй, хариуцлагыг дээдлэн, нөөцийг оновчтой, үр дүн, үр ашигтай ашиглаж хүн амд чанартай, аюулгүй тусламж үйлчилгээ үзүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргаас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
- Улсын хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттайгаас бусад эрүүл мэндийн байгууллага байгуулах, түүнд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргаж, тухайн шатны Засаг даргад танилцуулах;

- Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулах;
- Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих;
- Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн статистик мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тайлан, мэдээ, мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагад өгөх.

Эрүүл мэндийн салбарын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 6 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 6 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Эрүүл мэндийн салбарын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

| № | Байгууллагын ангилал | Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрлэсэн | Итгэл үзүүлсэн | Гэрээгээр хийлгэсэн | Аудитад хамрагдаагүй |
| 1 | Төсвийн шууд захирагч | 5 | 0 | 1 | 0 | - |
| | Дүн | 5 | 0 | 1 | 0 | - |

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн салбарын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн салбарын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бүртгэл мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийн салбарын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Засгийн газрын санхүүгийн "Э-тайлан" программ хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийн салбарын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Эрүүл мэндийн салбарын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийжээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрүүл мэндийн салбарын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Эрүүл мэндийн салбарын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 12051062,4 мянган төгрөг бөгөөд түүний *1* хувь болох *120510,6* мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Эрүүл мэндийн салбарын  болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 28210.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, 515.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан байна.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангиллаар үзүүлэв.Үүнд:

#### 2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

**Асуудал 1:  Аймгийн ЭМГ нь** Жинст сумын ЭМТ-ийн ажилтан Нандинцэцэгт 0,2 сая төгрөгийн тэтгэмжийг дутуу олгосон байхад өглөгөөр тусгаагүй.

**Шийдэл:** Санхүүгийн тайланд залруулсан

**Асуудал 2: Аймгийн ЭМГ нь** Унаа болон бусад нөхөн олговорт 10.4 сая төгрөг батлагдсан байхад гүйцэтгэлээр 49.0 сая төгрөг олгож цалин, нэмэгдэлийн зардлаас зарцуулсан байна.

**Шийдэл:** Зөвлөмж өгсөн

**Асуудал 3: Аймгийн ЭМГ нь** Улирал бүр ажилтнуудын ажлыг дүгнэж урамшуулал олгосон атлаа тушаалаар жилийн эцсийн ажлын гүйцэтгэлээр урамшуулалыг цалингийн зардлаас 5958.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон

**Асуудал 4: Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь** Кассын орлогоос 8536.2 мянган төгрөгийг Төрийн сангийн дансанд тушаалгүйгээр шууд  зарцуулсан.

**Шийдэл:** Зөвлөмж өгсөн.

**Асуудал 5: Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь** Хөдөлмөр хамгааллын зардлаас Барилгын хөгжлийн төвд 2018.02.13-нд  1944.0 мянган төгрөгийн магадлалын хөлсийг шилжүүлж зардалд бичсэн.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон

**Асуудал 6: Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь** Татварын хөнгөлөлтийг жилийн дүнгээр тооцож залруулга хийгээгүйгээс 1726.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын хөнгөлөлтийг дутуу суутгасан.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон

**Асуудал 7: Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь** Нийгмийн даатгалын тайлангийн цалин түүнтэй адилтгах орлогыг 1188580 төгрөгөөр илүү мэдээлсэнээс 273.4 мянган төгрөгийг илүү төлсөн.

**Шийдэл:** Төлбөрийн акт тогтоосон

**Асуудал 8: ЗӨСТ нь** Цалингийн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт болон сахилгын шийтгэлтэй албан хаагчид үр дүнгийн урамшуулал 9256,6 мянган төгрөг олгосон.

**Шийдэл:** Зөвлөмж өгсөн.

**Асуудал 9: Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг нь** Цалингаас суутгасан ҮЭ-ийн татварын 292,8 мянган төгрөгийг шилжүүлээгүй, НДШ-ийн 19,5 мянган төгрөгийг илүү суутгаж тайланд өглөгөөр тусгаагүй

**Шийдэл:** Санхүүгийн тайланд залруулсан.

### 2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчын шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд тооцох асуудал илрээгүй болно.

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

## 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрүүл мэндийн салбарын  чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 10064717.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 10034552.7 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн салбарын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Өмнө оны санхүүгийн тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2018 оныг “Санхүүгийн сахилга, хариуцлагыг сайжруулах жил” болгон ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Эрүүл мэндийн салбарын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй бөгөөд харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 1.8 хувь буюу 515.4 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 35,1 хувь буюу 9902,2 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 63,1 хувь буюу 17792,8 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

Мянган төгрөг

| № | Байгууллагын ангилал | Илрүүлэлт | | | | | | Залруулга | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөрчил | | Алдаа | | Бүгд дүн | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ТТЗ | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | ТШЗ | 5 | 27695.0 | 3 | 515.4 | 8 | 28210.4 | 3 | 515.4 |
| | Дүн | 5 | 27695.0 | 3 | 515.4 | 8 | 28210.4 | 3 | 515.4 |

### Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

Мянган төгрөг

| № | Байгуулла | Залруулаагүй | Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт |
|---|---|---|---|

| | гын ангилал | алдаа, зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах санал | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **1** | ТТЗ | - | - | - | | | - | - | - | - | - | - | - |
| **2** | ТШЗ | 5 | 27695.0 | 2 | 9902.2 | - | - | 3 | 17792.8 | - | - | - | - |
| | Дүн | 5 | 27695.0 | 2 | 9902.2 | - | - | 3 | 17792.8 | - | - | - | - |

## 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн салбарын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн салбарын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

| **№** | **Байгууллагын ангилал** | **Санал дүгнэлтийн хэлбэр** (Тоогоор) | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан | Дүн |
| **1** | ТШЗ | 5 | - | - | - | 5 |
| | Дүн | 5 | - | - | - | 5 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **682,335,133.47** | **810,743,576.17** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 2,000,000.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 2,000,000.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 2,000,000.00 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | 2,000,000.00 |
| **33** | **АВЛАГА** | 32,804,378.55 | 36,501,799.87 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 836,604.00 | 223,351.25 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 12,641,521.00 | 30,600,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 19,326,253.55 | 5,678,448.62 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 16,327,253.55 | 5,678,448.62 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 2,999,000.00 | - |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 600,000.00 | - |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 600,000.00 | - |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 600,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 648,930,754.92 | 772,241,776.30 |
| **351** | **Түүхий эд материал** | 259,716,066.82 | 366,956,661.95 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 114,890,542.12 | 163,261,219.10 |
| 35130 | Эм боох материал | 144,825,524.70 | 203,695,442.85 |
| **354** | **Хангамжийн материал** | 385,504,688.10 | 401,775,114.35 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,103,796.40 | 10,186,479.40 |
| 35420 | Аж ахуйн материал | 60,622,285.25 | 66,469,156.31 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 10,749,480.25 | 6,433,681.24 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,915,325.06 | 1,969,401.06 |
| 35450 | Барилгын засварын материал | 16,655,627.99 | 8,486,984.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,453,835.81 | 3,562,560.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 283,004,337.34 | 304,666,852.34 |
| 35600 | Мал амьтад | 3,710,000.00 | 3,510,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **10,596,800,689.19** | **13,090,148,766.77** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 10,596,800,689.19 | 13,090,148,766.77 |
| **392** | **Биет хөрөнгө** | 10,592,993,945.27 | 11,231,241,024.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 13,765,528,085.84 | 8,669,225,869.48 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (6,204,201,346.01) | (251,235,581.06) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 640,319,920.37 | 687,725,576.08 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (478,225,234.18) | (401,067,952.26) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 6,242,950,159.19 | 6,885,111,098.21 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (3,563,178,173.47) | (4,616,244,006.94) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 872,003,028.38 | 738,029,360.08 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (686,622,210.46) | (486,782,193.89) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 22,771,135.39 | 20,009,835.59 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (18,983,104.78) | (14,202,666.06) |
| 39217 | Ном | 631,685.00 | 671,685.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,806,743.92 | 1,858,907,742.54 |
| 39301 | Програм хангамж | 13,761,755.70 | 13,761,755.70 |

| | | | |
|---|---|---|---|
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (9,955,011.78) | (11,266,013.16) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 1,856,412,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **11,279,135,822.66** | **13,900,892,342.94** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **516,530.56** | **31,115,351.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 516,530.56 | 31,115,351.00 |
| **413** | **Өглөг** | 516,530.56 | 31,115,351.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 516,530.56 | 312,368.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 30,802,983.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 30,600,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 202,983.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **11,278,619,292.10** | **13,869,776,991.94** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 11,278,619,292.10 | 13,869,776,991.94 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 7,437,797,145.13 | 9,294,209,145.13 |
| 51101 | Өмч: - төрийн | 7,437,797,145.13 | 9,294,209,145.13 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (1,302,791,397.58) | (673,049,173.76) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (817,962,161.16) | (154,741,347.64) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (484,829,236.42) | (518,307,826.12) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 5,143,613,544.55 | 5,248,617,020.57 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **11,279,135,822.66** | **13,900,892,342.94** |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **10,640,126,003.49** | **11,532,754,609.41** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **762,777,547.49** | **953,730,354.15** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 188,821,830.92 | 405,487,199.55 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 188,821,830.92 | 405,487,199.55 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 163,999,746.00 | 147,891,503.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,933,652.00 | 161,593.33 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 18,888,432.92 | 257,434,103.22 |
| **122** | **Тусламжийн орлого** | 573,955,716.57 | 548,243,154.60 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 563,768,926.33 | 279,126,457.60 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | 10,186,790.24 | 269,116,697.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **9,877,348,456.00** | **10,579,024,255.26** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 6,152,481,800.00 | 6,554,748,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 6,152,481,800.00 | 6,554,748,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 312,788,957.00 | 661,434,219.26 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 142,058,557.00 | 104,795,744.26 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 40,883,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 40,200,000.00 | 272,885,871.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл | 130,530,400.00 | 242,869,604.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,412,077,699.00 | 3,362,841,736.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 83,168,791.00 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,328,908,908.00 | 3,362,841,736.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **11,123,817,178.77** | **11,660,394,381.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **11,123,817,178.77** | **11,660,394,381.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 9,788,340,577.91 | 10,347,060,430.03 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,063,056,939.23 | 5,320,369,465.91 |
| 210101 | Үндсэн цалин | 4,874,233,557.23 | 5,066,109,962.91 |
| 210102 | Нэмэгдэл | 119,983,380.00 | 163,111,120.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 21,265,634.00 |
| 210104 | Урамшуулал | 68,840,002.00 | 69,882,749.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 558,064,722.95 | 638,417,123.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 485,797,995.95 | 488,272,580.25 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 37,153,333.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 31,792,288.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 7,381,721.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 72,266,727.00 | 73,817,201.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 873,219,782.00 | 933,560,376.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 75,683,096.00 | 82,183,515.00 |
| 210302 | Түлш, халаалт | 670,882,008.00 | 725,862,128.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 126,654,678.00 | 125,514,733.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 305,029,198.58 | 257,428,295.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,617,410.00 | 39,688,426.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 136,240,000.00 | 136,830,249.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,329,256.18 | 13,324,466.48 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 51,838,293.48 | 55,804,127.94 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,353,244.68 | 10,150,664.98 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 593,600.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 69,057,394.24 | 1,630,361.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,567,801,112.06 | 1,638,629,541.48 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,337,210,431.56 | 1,396,059,635.67 |
| 210502 | Хоол, хүнс | 225,383,180.50 | 205,691,405.81 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,207,500.00 | 36,878,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 87,919,440.57 | 113,006,067.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,744,500.00 | 1,404,100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 90,000.00 | 4,276,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 84,084,940.57 | 107,325,567.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 37,247,223.00 | 37,180,460.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 37,247,223.00 | 37,180,460.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 218,130,113.40 | 261,010,791.26 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 180,658,968.40 | 239,671,553.26 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,421,500.00 | 3,160,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,534,200.00 | 2,694,725.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,655,900.00 | 2,397,725.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 445,300.00 | 425,178.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,823,900.00 | 11,507,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 481,660.00 | 263,980.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 307,000.00 | 407,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 18,801,685.00 | 483,030.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,077,872,046.12 | 1,147,458,309.73 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,943,600.00 | 23,062,368.90 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,627,000.00 | 995,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,050,301,446.12 | 1,123,400,940.83 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,335,476,600.86 | 1,313,333,951.27 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,210,588,867.00 | 1,251,805,069.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 83,168,791.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 277,484,680.00 | 327,842,683.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 695,184,576.00 | 914,170,886.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 154,750,820.00 | 9,791,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 124,887,733.86 | 61,528,882.27 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 124,887,733.86 | 61,528,882.27 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(483,691,175.28)** | **(127,639,771.89)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,138,061.14 | 390,668,054.23 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,138,061.14 | 16,659,483.07 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | - | 374,008,571.16 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (1,138,061.14) | (390,668,054.23) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(484,829,236.42)** | **(518,307,826.12)** |

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **10,049,629,100.62** | **10,741,557,279.26** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **183,547,748.62** | **147,891,503.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **183,547,748.62** | **147,891,503.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 183,547,748.62 | 147,891,503.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 163,999,746.00 | 147,891,503.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 19,548,002.62 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **9,866,081,352.00** | **10,593,665,776.26** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 6,152,481,800.00 | 6,554,748,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 6,152,481,800.00 | 6,554,748,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 301,521,853.00 | 676,075,740.26 |

| | | | |
|---|---|---|---|
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 142,058,557.00 | 116,591,265.26 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 40,883,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 40,200,000.00 | 273,731,871.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 119,263,296.00 | 244,869,604.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 3,412,077,699.00 | 3,362,841,736.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 83,168,791.00 | - |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,328,908,908.00 | 3,362,841,736.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **10,031,035,500.62** | **10,602,399,879.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,031,035,500.62** | **10,602,399,879.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **8,682,917,378.76** | **9,290,236,610.99** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,061,472,300.89 | 5,339,109,925.21 |
| 210101 | Үндсэн цалин | 3,417,867,695.89 | 3,285,113,256.21 |
| 210102 | Нэмэгдэл | 1,200,995,903.00 | 1,599,846,086.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 65,078,600.00 | 198,409,634.00 |
| 210104 | Урамшуулал | 377,530,102.00 | 255,740,949.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 558,107,716.69 | 621,342,063.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 402,881,044.69 | 459,215,210.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 38,806,618.00 | 40,279,196.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 31,045,374.00 | 32,962,987.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,761,344.00 | 8,082,307.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 77,613,336.00 | 80,802,363.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 874,409,704.00 | 932,670,876.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 75,668,047.00 | 82,264,715.00 |
| 210302 | Түлш, халаалт | 671,986,130.00 | 724,828,928.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 126,755,527.00 | 125,577,233.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 234,531,044.18 | 250,759,769.48 |
| 210401 | Бичиг хэрэг | 13,099,410.00 | 19,499,483.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 133,213,306.00 | 133,235,950.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,423,856.18 | 13,342,466.48 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 40,715,040.00 | 44,176,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 32,079,432.00 | 40,505,270.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,529,182,923.00 | 1,690,632,066.54 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,265,649,167.00 | 1,456,341,836.54 |
| 210502 | Хоол, хүнс | 222,106,456.00 | 201,182,730.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 41,427,300.00 | 33,107,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 95,970,795.00 | 112,957,550.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,902,194.00 | 13,637,800.00 |
| 210602 | Тавилга | 344,800.00 | 429,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,960,000.00 | 12,246,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 77,763,801.00 | 86,643,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 37,264,223.00 | 37,010,760.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 37,264,223.00 | 37,010,760.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 259,902,792.00 | 274,761,043.26 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 222,931,997.00 | 235,188,435.26 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,454,000.00 | 3,060,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,593,200.00 | 2,686,925.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,596,900.00 | 2,357,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 445,300.00 | 475,178.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 11,415,900.00 | 12,243,525.00 |
| 210807 | Газрын төлбөр | 481,660.00 | 263,980.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 307,000.00 | 584,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 17,676,835.00 | 17,901,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 32,075,880.00 | 30,992,557.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,750,880.00 | 29,997,557.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,325,000.00 | 995,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,348,118,121.86** | **1,312,163,268.27** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,210,588,867.00 | 1,250,634,386.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 83,168,791.00 | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 277,484,680.00 | 327,639,700.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 695,184,576.00 | 914,103,186.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 154,750,820.00 | 8,891,500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 137,529,254.86 | 61,528,882.27 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 137,529,254.86 | 61,528,882.27 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **18,593,600.00** | **139,157,400.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **18,593,600.00** | **137,157,400.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **18,593,600.00** | **137,157,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 18,593,600.00 | 137,157,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 18,593,600.00 | 137,157,400.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(18,593,600.00)** | **(137,157,400.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 2,000,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 2,000,000.00 |

## 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|---|---|---|---|
| D01 | 2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 7,437,797,145.13 | 5,143,613,544.55 | -1,302,791,397.58 | 11,278,619,292.10 | 11,278,619,292.10 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | -1,140,508,004.94 | 197,349,584.64 | -943,158,420.30 | -943,158,420.30 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 7,437,797,145.13 | 4,003,105,539.61 | -1,105,441,812.94 | 10,335,460,871.80 | 10,335,460,871.80 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 1,245,511,480.96 | 00.00 | 1,245,511,480.96 | 1,245,511,480.96 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 950,700,465.30 | 950,700,465.30 | 950,700,465.30 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 1,856,412,000.00 | 00.00 | -518,307,826.12 | 1,338,104,173.88 | 1,338,104,173.88 |
| D09 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 9,294,209,145.13 | 5,248,617,020.57 | -673,049,173.76 | 13,869,776,991.94 | 13,869,776,991.94 |

## 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 10,064,717,700.00 | 10,034,552,656.73 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 10,064,717,700.00 | 10,034,552,656.73 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 9,002,281,200.00 | 8,978,448,538.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,205,900,900.00 | 5,201,412,130.21 |
| 210101 | Үндсэн цалин | 3,033,452,700.00 | 3,147,415,461.21 |
| 210102 | Нэмэгдэл | 1,696,832,200.00 | 1,599,846,086.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 204,058,000.00 | 198,409,634.00 |
| 210104 | Урамшуулал | 271,558,000.00 | 255,740,949.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 625,800,500.00 | 621,216,988.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 415,536,200.00 | 459,090,135.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 51,992,900.00 | 40,279,196.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 43,886,900.00 | 32,962,987.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,398,600.00 | 8,082,307.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 103,985,900.00 | 80,802,363.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 940,819,700.00 | 932,670,876.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 85,802,300.00 | 82,264,715.00 |
| 210302 | Түлш, халаалт | 727,755,200.00 | 724,828,928.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 127,262,200.00 | 125,577,233.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 255,588,400.00 | 254,763,801.48 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,512,100.00 | 18,548,415.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 135,977,900.00 | 132,941,150.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 15,092,800.00 | 13,342,466.48 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 44,780,200.00 | 44,176,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 45,225,400.00 | 45,755,170.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,639,000,800.00 | 1,637,629,417.54 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,405,046,700.00 | 1,403,339,187.54 |
| 210502 | Хоол, хүнс | 200,877,800.00 | 201,182,730.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 33,076,300.00 | 33,107,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 210,060,100.00 | 210,783,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 50,677,400.00 | 52,952,300.00 |
| 210602 | Тавилга | 82,690,000.00 | 77,992,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 14,286,300.00 | 12,701,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 62,406,400.00 | 67,137,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 34,762,700.00 | 34,406,760.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 34,762,700.00 | 34,406,760.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 56,910,500.00 | 54,572,608.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,000,000.00 | 15,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 3,310,100.00 | 3,060,100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,818,300.00 | 2,686,925.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2,480,500.00 | 2,357,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 565,200.00 | 475,178.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 13,177,600.00 | 12,243,525.00 |
| 210807 | Газрын төлбөр | 786,900.00 | 263,980.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 686,000.00 | 584,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 18,085,900.00 | 17,901,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 33,437,600.00 | 30,992,557.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 31,346,300.00 | 29,997,557.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,091,300.00 | 995,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,062,436,500.00 | 1,056,104,118.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,062,436,500.00 | 1,056,104,118.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 327,639,700.00 | 327,639,700.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 732,946,800.00 | 726,614,418.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,850,000.00 | 1,850,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 10,064,717,700.00 | 10,034,552,656.73 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 6,554,748,300.00 | 6,523,819,417.73 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 6,554,748,300.00 | 6,523,819,417.73 |

| | | | |
|---|---|---|---|
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,363,798,400.00 | 3,362,841,736.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 3,363,798,400.00 | 3,362,841,736.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 146,171,000.00 | 147,891,503.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 146,171,000.00 | 147,891,503.00 |